

БАТЛАВ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА  С.МӨНХНАСАН

ХЯНАН БАТАЛГААЖУУЛАХ ГЭРЭЭ

№.08/22

2022 оны 3 сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү Хянан баталгаажуулах гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас Иргэний нисэхийн ерөнхий газар /цаашид “А” тал гэх/-ыг төлөөлж Агаарын тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Г.Батбаяр, нөгөө талаас Гадаад харилцааны яамны дэргэдэх Орон тооны бус орчуулгын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Олон Улсын гэрээ, эрх зүйн газрын 1 дүгээр нарийн бичгийн дарга Жамбалдоржийн Соёлмаа, (цаашид “Б” тал гэх) (хамтад нь “Талууд” гэх) нар нь дараах нөхцөлөөр харилцан тохиролцож Монгол Улсын Иргэний хуулийн 359-368 дугаар зүйл Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 7 дугаар зүйл болон холбогдох бусад хууль, эрх зүйн актыг удирдлага болгон энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Б тал нь Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-т 2015 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан протоколын орчуулгыг хянан баталгаажуулалт хийж үйлчлэх бөгөөд энэхүү Гэрээ нь ажлын зохих хөлсийг төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Б тал нь Гэрээнд заасан ажлыг гэрээнд заасан болзол, нөхцөл ба тохиролцсон хөлсөөр гүйцэтгэх, А тал нь Б талын ажил үүргээ гүйцэтгэх нөхцөлийг бүрэн хангаж, Гэрээгээр тохиролцсон хөлс олгох нь энэхүү Гэрээний гол зүйл мөн.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1 Энэхүү гэрээг байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр гэж үзэх бөгөөд Б талын хариуцан хийх ажил дуусгавар болсноор Гэрээ дуусгавар болно. Гэрээний 1.1-т заасан ажлыг гэрээ байгуулснаас хойш 14 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.

2.2 Талууд гэрээний хугацааг сунгах эсэх асуудлыг энэхүү гэрээний 2.1-т заасан хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

2.3 Гэрээний хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулахаар бол талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээнд нэмэлт заалтуудыг хавсралтаар оруулж болно.

ИНЕГ
ХЯНАН

2.4 Гэрээний хугацаа дуусахад биелэлтийг талууд харилцан дүгнэж, гүйцэтгэлийн баримт бичиг үйлдэнэ.

Гурав. Ажлын хөлс олгох

3.1 А тал Б талд дараах хөлсийг олгоно:

3.1.1. Монгол Улсын Гадаад харилцааны сайдын 2017 оны А/73 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын олон улсын гэрээний орчуулга хийх, хянан баталгаажуулах журам”-ыг үндэслэн хянан баталгаажуулах хөлс нэг нүүр 30,000 төгрөг байна. Хянан баталгаажуулалтыг нийт 15 нүүрээр тооцож нийт 450,000 төгрөг байна.

3.2 Төлбөрийн 50 хувийг гэрээ байгуулсны дараа, үлдсэн 50 хувийг ажил дуусгавар болсноос хойш ажлын 5 хоногт багтаан нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг тус тус суутгаж олгоно.

3.3 Төлбөрийг Б тал /Жамбалдоржийн Соёлмаа/-ын Хаан банкны 5175282580 дугаар төгрөгийн дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг

4.1 А тал нь дараах эрх, үүрэгтэй:

- 4.1.1. Б талд энэхүү Гэрээгээр тохирсон хөлс олгох;
- 4.1.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг нөгөө талаас шаардах;

4.2 Б тал нь дараах эрх, үүрэгтэй:

- 4.2.1. Энэхүү гэрээнд заасан ажил үүргийг бүрэн хариуцаж энэхүү гэрээний 2.1-д заасан хугацаанд чанартай сайн гүйцэтгэх.
- 4.2.2. А талын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийн нууцыг чандлан хадгалах бөгөөд өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх.
- 4.2.3. Ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутам 0,5 хувийн алданги төлнө.

Тав. Давагдашгүй хүчин зүйл

5.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги / чөлөөлөгдөх үндэслэл болно.



Зургаа. Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар

6.1 А тал энэхүү гэрээг байгуулахад ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаараа доорх заалтын дагуу мэдэгдэнэ.

6.1.1 А тал энэхүү гэрээг байгуулахад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй эсэх;

Тийм Үгүй
/доогуур зурна уу/

6.2 Б тал энэхүү гэрээг байгуулахад ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаараа доорх заалтын дагуу мэдэгдэнэ.

6.2.1 Б тал энэхүү гэрээг байгуулахад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй эсэх;

Тийм Үгүй
/доогуур зурна уу/

6.3. Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх асуулгад тийм гэж хариулсан тохиолдолд энэхүү гэрээ байгуулах үйл ажиллагаа дуусгавар болно.

6.4. Уг асуулгад үгүй гэж хариулсан боловч ашиг сонирхлын зөрчилтэй болох нь тогтоогдсон тохиолдолд гэрээ хүчингүй болж, гэрээ байгуулахад оролцсон бүх этгээдүүд хуульд заасан хариуцлага хүлээнэ.

Долоо. Бусад зүйл

7.1 Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/-аар албажуулснаар хүчин төгөлдөр болно.

7.2. Гэрээний явцад талуудын хооронд үүссэн маргааныг талууд харилцан тохиролцоо замаар эвийн журмаар шийдвэрлэнэ.

7.3. Хэрэв Талууд аливаа маргаантай асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд уг маргаантай асуудлыг Монгол Улсын шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

7.3 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахад Талууд тэгш эрх эдэлж, оруулсан нэмэлт, өөрчлөлтийг гэрээнд хавсаргаснаар энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй болно.

7.4 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.



7.5 Гэрээг 3 хувь үйлдэж А тал 2 хувийг, Б тал 1 хувийг хадгална. Гэрээний хувиуд хууль зүйн хувьд нэгэн адил хүчинтэй байна .

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

А ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

Б ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН АГААРЫН ТЭЭВРИЙН
БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА Г.БАТБАЯР

ГАДААД ХАРИЛЦААНЫ ОЛОН УЛСЫН
ГЭРЭЭ ,ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН I НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ж.СОЁЛМАА



/гарын үсэг/

/гарын үсэг/

Утас: 99119091

Утас: 99997020

